



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 10 сарын 16 өдөр

Дугаар 507

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дарханы дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 8 нэрийн, нийт 234,019,200.86 (хоёр зуун гучин дөрвөн сая арван есөн мянга хоёр зуун төгрөг наян зургаан мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, “Дарханы дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Д.Батжаргал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр худалдах, орлогыг компанийн дансанд төвлөрүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл) -т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132002284

22-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн
... дугаар тогтоолын хавсралт

"ДАРХАНЫ ДУЛААНЫ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ ДАНСНААС
ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Хөрөнгийн код	Ашиглалтад орсон огноо	Диаметр /мм/	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ, хуригтлагдсан элэгдэл (төгрөг)
1	Түгээх сүлжээний К51.01-К51.02 хоорондох халаалтын шугам	2001069006	1965	ф219	м	104	271,905.99	28,278,222.96
2	Түгээх сүлжээний К81-К81.08-ийн хооронд шугам хоолой	2001145	1965	ф350	м	60	645,307.70	38,718,462.00
3	Түгээх сүлжээний К72.08-К72.12-ийн хооронд шугам хоолой	2001061029	1965	ф89	м	110	111,014.02	12,211,542.20
4	ДЦСтанцын 2- секцийн харалдаа ф800 мм-ийн өгөх шугамын шилжүүлгээс К78-н хооронд ф600 мм-ийн шугам	2001055004	1965	ф600	м	51	1,128,114.94	57,533,861.94
5	ДХТ№6-н 2-р хэлхээний салбар шугам ДХ7-ДХ9 хоорондох ф159, ф89, ф50 XX ус халаалт циркуляц	2001055004	1965	ф159	м	664	134,786.94	89,498,528.16
6	2-р хороолол ДХ28-ДХ31 хоорондох 60 хос метр шугам	2001095	1965	ф25	м	120	19,446.46	2,333,575.20
7	2-р хороолол ДХ28-ДХ31 хоорондох 60 хос метр шугам	2001096				120	27,008.97	3,241,076.40
8	2-р хороолол ДХ28-ДХ31 хоорондох 60 хос метр шугам	2001096				120	18,366.10	2,203,932.00
								234,019,200.86
Нийт дүн								(хоёр зуун гучин дөрвөн сая арван есөн мянга хоёр зуун төгрөг наян зургаан мөнгө)